



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэрийн, нийт 48,471,729.00 (дөчин найман сая дөрвөн зуун далан нэгэн мянга долоон зуун хорин есөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Эрэвгийлхам, гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000721

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 378 дугаар тогтоолын хавсралт



**"Дорноговь-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Хийн компрессор	2009	ш	1	25,508,318.00	25,508,318.00
2	Цахилгаан үүсгүүр	2009	ш	1	21,445,411.00	21,445,411.00
3	Вагончик	1995	ш	1	1,518,000.00	1,518,000.00
	Нийт дүн			3 (гурав)		48,471,729.00 (дөчин найман сая дөрвөн зуун далан нэгэн мянган долоон зуун хорин есөн)